

Жамбын ДАШДОНДОГ

# Талайхан



Ж.Дашдондог  
**ГАЛАЙХАН**

Сургуулийн бага, дунд насныханд зориулав.

Зураач М.Буян  
Хянан тохиолдуулагч О.Мөнхтуяа  
Дизайнер Т.Дэлгэрмаа



Хэвлэн нийтлэлийг Интерпресс ХХК

2007 он



**Д**орнод Монголын мөнгөн цагаан талаар жингийн цуваа жирийсэн өвлийн нэгэн жихүүн үдэш эл үлгэр эхэлвэй.

Хилийн дээс алхсан атан тэмээдийн хөл хөнгөрөөд шөнөжин зүтгүүлэвч цуцах шинжгүй. Гэсэн хэдий ч хашир жинчид урьдын адил буурь сунгахаас төвдөн, дүүжин холын жинд аянширсан хөсгөө буулгажээ.

Төдөлгүй төвхөнөсөн мань хэд тулгын гурван чулуунд аргал зээглээд ган хэтээ цахиж, гал хөсөө базаан аяганы хийцээ дэлгэв. Өвгөн жинчин гүзээтэй шар тосноосоо галдаа өргөөд “Эгүүлэн нэвт униарт, этүгэн нэвт илчит, торгон нүүрт, тосон царайт гал галайхан минь хурай, хурай, хурай!” гэв. Цэнхэр дөл шар шар хийн цоролзох нь балчир жаал ход ход хийн инээх мэт. Жинчид модон тужиргандаа ааруул, цагаан тос овоолоод цай цүй болж суутал галан хүрээнээс дөлөн хүүхэд гэнэт тасран гарч:

-Намайг дуудав уу? гээд дэгдэн гүйлээ.



- Хэн юм бэ, чи?

- Би галын хүү, Галайхан!

- Ай даа, ёстой нүүрэндээ цогтой, нүдэндээ галтай хүү байна шүү. Тийнхүү тэд Галайханыг магтаж, гялайснаа хэлж дуусаагүй шахам байтал нөгөө гайхал галын хэлээр:

- Би өлсөж байна! гээд модон аягыг нь шүүрэн авч яах ийхийн зуургүй хүлхчихэв.

Тэгтэл сийгэн сүүгэн явдалтай салхин хүлгийн чимээ гарлаа. Унасан эзэн Салхин хүү нь улам дэвэргээд:

- Уласхий, уухайс! Ухасхий, уухайс! хэмээн исгэчхэд, зүрх нь хөөрсөн Галайхан хөмөн богцноос хөх майхныг нь хүртэл зажлалгүй залгиж орхив. Салхины хүү хөгжөөхөд галын хүү даварсаар алт, эрдэнэс, хоргой, торго дүүрэн ачаа бараа уруу нь дүрэлзээд орох нь тэр. Жинчид сандран “Хүүе, хаая” болон хашгиралдаж усны хүүг урин дуудлаа. Чих зөөлөн



Усанхүү ч дорхноо л цэлэлзээд ирж.  
Галайхан түүнээс сүнс зайлтал айх тул ум  
хумгүй дутаан одов. Чингэхдээ харганын  
мөчрөөс зууран авч:

-Заяахав, хүндхэрэггүй бол эндунтсуу!  
гээд сүүмийн сүүмийсээр алга болжээ.  
Салхинхүү түүнд тусалчих санаатай  
хэчнээн үлээвч сэрээж барсангүй.

Жинчид салхи хаах майхангүй болсон  
ч бараа тээштэй үлдсэндээ баярлан энэ  
тэрийг ярилцсаар хажуулжээ.

Тэгсэн чинь жаварт зүлгүүлж  
гялалзсан зургаан мөнгөн мичид бүүдгэр  
тэнгэрт живж, хуйрнан шуугих их дуу чих  
дэлдэв гэнэ. Яав ийв бололцон өндийвөл  
Цасанхүү, Шуурганхүү хоёр үгсэн  
хавсайдаад нүүр нүдгүй үлээж байлаа.  
Азарган нэхий дээлийг нэвт жиндүүлэх  
тул ямаан дахаар хучив.

- Энэ ч яахав Салхинхүүгийн л балаг.

- Галайханг хөөсөнд хорсож, ганцаар





үлдсэндээ бухимдсаар хүйтэн хошуут садан төрлөө л дуудаа биз хэмээн жинчид ярилцана.

Цасанхүү, Шуурганхүү хоёр зуузай холбон довтлох нь түмэн галзуу арслан зогдор дэлээ хийсгэн яваа мэт аймшигтай. Хөлд нь хүрсэн бүхэн хөлдөж царцана. Мянган дах нөмрөн хэвтлээ ч нэмэргүй. Тэгтэл арай ядан амь хоргоож байсан ямаан дахыг нь сайх хоёр хуу татан газар тэнгэрийн савсалга уруу шидэж орхив. “Нутаг усандаа хүрч чадалгүй ингээд хөлдүүс болдог байжээ” хэмээн түгшсэн жинчдийн санаанд гэнэт Усанхүү туслагч нь орлоо. Түүнийг дуудсан чинь хүрч ирэх нь байтугай хөдлөх ч тэнхэлгүй тэс хөлджээ.

Амь нас уу, алт мөнгө үү? гэдэг дээрээ туллаа. Аврах ачтан л гараад ирдэг юм бол тэдэнд арван тэмээ алт, хорин тэмээ хоргой амлах ч энүүхэнд.



Гэвч үхэл хэдийн ирчхээд авч явахаар хүлээж байлаа. Жинчдийн хөшсөн амнаас сүүлчийн удаа “Галайхан” гэсэн үг гарчээ. Цасанхүү, Шуурганхүүгийн хөлийн ширвээнд нойроос сэрж ядан байсан Галайхан түүнийг сонсон баясч, сунисаар инээсээр нэг мэдэхэд босоод ирлээ шүү. Осгосон хүмүүсийг тойрон бүжихэд гэрэл сацарсан халуун амнаас нь үхэл, харанхуй хоёр цэрвэж, агшин зуур зайлан одов. Цасанхүү, Шуурганхүү хоёр ч тэгсгээд дайжин холджээ. Жинчид дулаацан амь орж, галын хүүгийн гараас атгаж тавин:

-Алтан сэтгэлт хүү минь мөчид ухаант биднийгээ өршөө! гэж ам амандаа хэлэв. Удалгүй Усанхүү амилан хөдөлж, Галайханаас ичсэндээ тогоонд сэмхэн ороод цай болж даргин буцлав. Тэндээс гарсан сонин аялгуунд Галайхан баясч ийнхүү дууллаа:



*Би - Галайхан!*

*Би - Галын хүү!*

*Асч л байвал намайгаа*

*Альд л явна гэж санаарай!*

*Унтарч орхивол намайгаа*

*Унтаж байна гэж бодоорой!*

*Би - Галайхан!*

*Би - Галын хүү!*

*Өөдөө дүрэлзэх эрдмийг минь*

*Өргөнө үү, байна уу, өөрснөө мэд!*

*Дээшээ цоролзох хүслийг минь*

*Дэлжинэ үү, дарна уу, өөрснөө мэд!*

Жинчид тэр дууг хурайлан түрээд, арга билэг хосолсон түмэн жилийн тахилгат гал Галайхандаа мөргөж, өөх тосоор мялаана. Дөлийн намираан бүжиг, галын чамин аялгуу шөнөжин үргэлжлэв. Чингээд дулаацахын жаргал эдэлсэн хэд маань ачит Галайхан хүүгээ алжааж ядрах вий гэсэн мэт зөөлөн бүүвэйлж түр нойрсуулаад, марлын гялаанаар ачаалж нутгийн зүг хөсгөө хөдөлгөвөй. Арын тэмээний хонхны дүн дон дуутай жингийн сүүл хөөгчийн "Хай хээг!" гэх чимээ хослох нь сэтгэлд юутай яруу.





Дэлхийн банктэй хамтран хэрэгжүүлж буй  
«Хөдөөгийн боловсролыг дэмжих  
(READ) төсөл»-ийн хүрээнд хэвлэв.  
Худалдахыг хориглоно.